

## Хүүхдийн эмчийн /ажиллагсад/ мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил-1

Сорилын зөв хариулт

1-С, 2-В, 3-А, 4-С, 5-А, 6-А, 7-Д, 8-Д, 9-А, 10-Е, 11-В, 12-А, 13-С, 14-Д, 15-В, 16-В, 17-В, 18-В, 19-В, 20-С, 21-А, 22-С, 23-С, 24-Д, 25-А, 26-В, 27-С, 28-В, 29-Е, 30-А, 31-Е, 32-Е, 33-С, 34-В, 35-Е, 36-Д, 37-Д, 38-А, 39-С, 40-Е, 41-А, 42-В, 43-А, 44-В, 45-Е, 46-А, 47-Е, 48-А, 49-А, 50-Д, 51-Д, 52-В, 53-А, 54-А, 55-В, 56-Д, 57-В, 58-С, 59-С, 60-А, 61-Е, 62-В, 63-В, 64-С, 65-А, 66-А, 67-С, 68-Е, 69-С, 70-В, 71-С, 72-Д, 73-С, 74-С, 75-В, 76-А, 77-В, 78-В, 79-В, 80-В, 81-В, 82-С, 83-Д, 84-В, 85-Д, 86-А, 87-С, 88-В, 89-Е, 90-Д, 91-В, 92-В, 93-В, 94-А, 95-Д, 96-А, 97-А, 98-А, 99-С, 100-С, 101-С, 102-В, 103-С, 104-С, 105-В, 106-А, 107-С, 108-Д, 109-В, 110-В, 111-В, 112-А, 113-В, 114-В, 115-Е, 116-В, 117-А, 118-В, 119-В, 120-В, 121-Д, 122-А, 123-А, 124-А, 125-В, 126-В, 127-В, 128-С, 129-В, 130-С, 131-Е, 132-С, 133-В, 134-А, 135-С, 136-В, 137-А, 138-С, 139-А, 140-Д, 141-С, 142-А, 143-Д, 144-Д, 145-В, 146-В, 147-С, 148-А, 149-А, 150-В, 151-А, 152-В, 153-В, 154-А, 155-С, 156-А, 157-С, 158-В, 159-Д, 160-С, 161-С, 162-Д, 163-В, 164-А, 165-Д, 166-Д, 167-В, 168-Е, 169-А, 170-В, 171-А, 172-А, 173-С, 174-С, 175-С, 176-А, 177-Е, 178-А, 179-Д, 180-А, 181-А, 182-А, 183-А, 184-С, 185-А, 186-А, 187-Д, 188-А, 189-А, 190-А, 191-А, 192-А, 193-А, 194-А, 195-С, 196-С, 197-Д, 198-С, 199-А, 200-А, 201-А, 202-А, 203-А, 204-А, 205-С, 206-А, 207-Д, 208-В, 209-А, 210-С, 211-С, 212-В, 213-Е, 214-А, 215-С, 216-А, 217-Д, 218-В, 219-С, 220-С, 221-Д, 222-А, 223-В, 224-В, 225-Д, 226-С, 227-Д, 228-Д, 229-Д, 230-В, 231-Д, 232-А, 233-Д, 234-Д, 235-В, 236-Е, 237-А, 238-В, 239-А, 240-С, 241-Д, 242-С, 243-Е, 244-В, 245-В, 246-А, 247-В, 248-Д, 249-Д, 250-В, 251-Д, 252-А, 253-С, 254-А, 255-Е, 256-В, 257-Д, 258-В, 259-С, 260-А, 261-А, 262-Е, 263-Е, 264-С, 265-А, 266-С, 267-А, 268-Е, 269-А, 270-А, 271-А, 272-Е, 273-Д, 274-А, 275-Д, 276-В, 277-В, 278-С, 279-А, 280-А, 281-А, 282-А, 283-А, 284-В, 285-С, 286-С, 287-Д, 288-В, 289-А, 290-С, 291-А, 292-С, 293-А, 294-С, 295-В, 296-В, 297-С, 298-А, 299-Д, 300-Д, 301-В, 302-В, 303-С, 304-С, 305-С, 306-В, 307-Д, 308-В, 309-С, 310-Д, 311-С, 312-С, 313-А, 314-С, 315-А, 316-Д, 317-Д, 318-С, 319-Д, 320-В, 321-А, 322-С, 323-Д, 324-Е, 325-В, 326-В, 327-Д, 328-Д, 329-С, 330-С, 331-Е, 332-Е, 333-С, 334-Д, 335-С, 336-Д, 337-Д, 338-Е, 339-В, 340-Д, 341-Е, 342-С, 343-А, 344-Е, 345-Д, 346-Е, 347-В, 348-В, 349-Е, 350-Д, 351-А, 352-С, 353-Д, 354-С, 355-Е, 356-Е, 357-А, 358-В, 359-Е, 360-Д, 361-В, 362-В, 363-Е, 364-Д, 365-Д, 366-В, 367-Е, 368-Д, 369-Д, 370-С, 371-С, 372-Д, 373-С, 374-Е, 375-Д, 376-В, 377-Е, 378-А, 379-Д, 380-А, 381-Д, 382-Е, 383-С, 384-Е, 385-Е, 386-Д, 387-Д, 388-В, 389-Д, 390-Е, 391-Д, 392-А, 393-А, 394-А, 395-Д, 396-Е, 397-А, 398-Д, 399-А, 400-С, 401-Д, 402-С, 403-Е, 404-Е, 405-А, 406-С, 407-В, 408-С, 409-А,

1. Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )
  - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
  - 1,2, 3, 4-р хариултууд зөв бол (В.)
  - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
  - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
  - Бүх хариулт зөв бол (Е.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
  - Зөв, Зөв, Зөв (А.)
  - Зөв, Зөв, Буруу (В.)
  - Зөв, Буруу, Буруу (С.)
  - Буруу, Зөв, Буруу (D.)
  - Буруу, Буруу, Буруу (Е.)

/1./ Нярайн жингийн алдагдлыг хэдэн хувиас эхлэн дээш байвал эмгэг гэж үзэх вэ?

- А. 6%
- В. 8%

C. 10%

D. 12%

E. 15%

/2./ 38,5 хэмээс дээш хэлуурч буй 4 настай хүүхдэд парацетамолын 500 мг-ын шахмалаас яаж өгөх вэ?

A. 1\4

B. 1\2

C. . 1 бүтнээр

D. 1,5

E. 2 бүтнээр

/3./ Амьсгал дутлын зэргээс хамаарч хийгдэх хамгийн тохиромжтой байж болох эмчилгээг сонгоно уу.

A. Амьсгал дутлын 1-р зэрэг

B. Амьсгал дутлын 2-р зэрэг

C. Амьсгал дутлын 3-р зэрэг

1. Өрөөний агаарыг хэт салхилуулахгүй, өдөрт 4-6 удаа солино.

2. 4% содын уусмал 2-4 мл/кг жинд нь тооцож, суудсанд хийнэ.

3. Чийглэсэн 30-40% хүчилтөрөгчийг ялимгүй даралтай хэрэглэнэ. мм.муб

A. A1, B3, C2

B. A1, B2, C3

C. C1, B2, A3

D. A2, B3, C1

E. A3, B1, C2

/4./ Хүүхдийн хэдэн насанд хэл ярианы хөгжилд нь илүү анхаарах шаардлагатай вэ?

A. 1-2 нас

B. 2-3 нас

C. 3-7 нас

D. 7-9 нас

E. 9-12 нас

/5./ 24 хоногтой нярайн арьсан дээр ганц нэг идээт цэврүү гарсан, өөр өвчний шинжгүй бол ямар арга хэмжээ авах вэ?

A. Хэсэг газрын нянгийн халдвар гэж ангилад үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын эмчилгээ хийгээд, 2 хоноод давтан үзнэ.

B. Нянгийн хүнд халдвар байж болзошгүй гэж ангилаад, антибиотикийн эхний тунг тариад, цусны сахар багасхаас сэргийлээд, дулаан авч явахыг зөвлөөд, эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

C. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эм уулгаад эмнэлэгт хэвтүүлнэ

D. Яаралтай эмнэлэгт хэвтүүлнэ.

E. Антибиотик тариад гэрт нь эмчилнэ, 5 хоноод давтан үзнэ.

/6./ 1 нас 6 сартай. амьсгал гаргалт шуугиантай байгаа хүүхдэд сальбутамолын 4 мг шахмалыг яаж өгөх вэ?

A. 1x2-ээр өдөрт 3 удаа

B. 1x2-ээр өдөрт 4 удаа

C. 1x4-ээр өдөрт 3 удаа

D. 1x4-ээр өдөрт 4 удаа

E. 1 шахмалаар 1 удаа

/7./ Зүрхний гялтангийн адгезив үрэвслийн үеийн хамгийн оновчтой эмчилгээг зөв сонгоно уу.

A. Глюкокортикоид

B. Шээс хөөх бэлдмэл

C. Шинж тэмдгийн эмчилгээ

D. Мэс засал

E. Антибиотик эмчилгээ

/8./ 8 сартай хүүхэд халуурсан, татсан зовиуртай үзүүлэхэд хүүхдийн халуун 39 хэм, таталт намдсан боловч маш их шаналгаатай, чихнээс булаг гойжоод сар болж байгаа гэвч үзлэгээр чихний ард хөндүүр хавагнасан улайлт байв. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?

A. Аюултай ерөнхий шинжтэй. Чихний архаг халдвар

- B. Маш хүнд халууралт өвчин. Чихний архаг халдвар
- C. Хөхлөг ургацын үрэвсэл
- D. Маш хүнд халууралт өвчин. Хөхлөг ургацын үрэвсэл
- E. Маш хүнд халууралт өвчин. Чихний цочмог халдвар.

/9./ 24 хоногтой нярайн арьсан дээр ганц нэг идээт цэврүү гарсан, өөр өвчний шинжгүй бол өрхийн эмч ямар арга хэмжээ авах вэ?

A. Хэсэг газрын нянгийн халдвар гэж ангилад үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын эмчилгээ хийгээд, 2 хоноод давтан үзнэ.

B. Нянгийн хүнд халдвар байж болзошгүй гэж ангилаад, антибиотикийн эхний тунг тариад, цусны сахар багасхаас сэргийлээд, дулаан авч явахыг зөвлөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

C. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эм уулгаад эмнэлэгт хэвтүүлнэ

D. Яаралтай эмнэлэгт хэвтүүлнэ.

E. Үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын халдварыг генцианвиолетээр гэрт нь эмчлэнэ, 5 хоноод давтан үзнэ.

/10./ Төрөх өрөөний дулаан доод тал нь хэдэн хэм байх ёстой вэ?

A. 21

B. 22

C. 23

D. 24

E. 25

/11./ 6 сартай 8 кг жинтэй хүүхэд 2 хоног суулгасан зовиуртай, үзлэгээр хүүхдийн нүд хонхойсон, ам нь их цангасан, ховдоглон ууж байв. Өөр шинж илрээгүй. Хүүхдийн биеийн байдлыг үнэлж ямар арга хэмжээ авах вэ?

A. Хүнд шингэн алдсан гэж үзээд хураагуур судсанд шингэн юүл.

B. Шингэн алдсан гэж үнэлээд 4 цагийн дотор 450-800 мл ШСД цайны халбагаар уулга.

C. Шингэн алдсан гэж үзээд 800-1200 мл ШСД бага багаар уулга.

D. Шингэн алдалтгүй гэж үнэлээд А төлөвлөгөөний дагуу эмчил.

E. Шингэн их алдсан гэж үнэлээд 100 мл/кг жинд тооцоолон Рингер лактат дуслаар хий.

/12./ Улаан хоолойн орох хэсэг нярайд хаана байрладаг вэ?

A. CIII-CIV

B. CII-CIII

C. CIV-CV

D. CV-CVI

E. CVI-CVII

/13./ 38,5 хэмээс дээш хэлуурч буй 8 сартай хүүхдэд парацетамолын 100 мг-ын шахмалаас яаж өгөх вэ?

A. 1\4

B. 1\2

C. 1 бүтнээр

D. 1,5

E. 2 бүтнээр

/14./ Амьсгал дутлын зэргээс хамаарч илрэх эмнэлзүйн гол шинжүүд нь:

A. Амьсгал дутлын 1-р зэрэг

B. Амьсгал дутлын 2-р зэрэг

C. Амьсгал дутлын 3-р зэрэг

1. Цусны рН 7.2 –оос бага, үл зохицох хүчилшилтэй

2. Судасны лугшилт, амьсгалын тооны харьцаа нэг минутанд 3.5:1, цусны хүчилтөрөгчийн хангамж 85 мм.муб хүртэл буурсан

3. 3.Тайван үед амьсгаадна, цусны хүчилтөрөгчийн хангамж 70- 85 мм.муб

A. A1, B3, C2

B. A1, B2, C3

C. C1, B2, A3

D. A2, B3, C1

E. A3, B1, C2

/15./ ХӨЦМ –ийн зөвлөмжөөр цусан суулгалтад аль антибиотикийг уулгахаар зөвлөдөг вэ?

A. Амоксациллин

- B. Цифрофлаксацин
- C. Кларитромицин
- D. Тетрациклин
- E. Эритромицин

/16./ Нярайн булчин дахь миофибриллийн уургууд ахлах насны хүүхдийнхээс хэд дахин бага байдаг вэ?

- A. 3
- B. 2
- C. 4
- D. 1
- E. Ижил байдаг

/17./ Сампингийн эрхийн шинжийг хаана тэмтэрч үзэх вэ?

- A. Өвчүүний эрмэгээр.
- B. Хавирганы ясан эд мөгөөрсөн эдэд шилжих хэсэгт.
- C. Суганы урд шугамаар
- D. Суганы дунд шугамаар
- E. Суганы арын шугамаар

/18./ Хүйнээс нь идээ гарч байгаа, 1 өдөр халуурсан нярайд ямар ангиллаар, ямар тусламж үзүүлэх вэ?

A. Хэсэг газрын нянгийн халдвар гэж ангилаад үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын эмчилгээ хийгээд, 2 хоноод давтан үзнэ.

B. Нянгийн хүнд халдвар буюу маш хүнд өвчин гэж ангилаад, антибиотикийн эхний тунг тариад, цусны сахар багасхаас сэргийлээд, дулаан авч явахыг зөвлөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

C. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эм уулгаад гэртээ хэрхэн асрах талаар эхэд зааж өгнө.

D. Антибиотик тариад гэрт нь эмчилнэ.

E. Үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын халдварыг генцианвиолетээр гэрт нь эмчлэнэ

/19./ Таталдамхай өвчний ил хэлбэрийн эмнэлзүйн шинжүүдийг зөв тодорхойлно уу:

- A. Дууны хөвч агчилт
- B. Ул сарвууны таталт
- C. Эклампси

1. Сарвуу “эх баригч”, тавхай “адууны туурай”-ны шинж бүхий таталт өгөх

2. Амьсгал тасалдаж, царай цонхийж хөхрөх, татах, хоолой сөөнгөтөх

3. Ухаан алдах, амнаас хөөс сахрах, таталт нүүрний булчингаас эхлэн бүх биеийг хамрах, мэдээгүй бие засах

- A. A1, B3, C2
- B. A2, B1, C3
- C. C1, B2, A3
- D. A2, B3, C1
- E. A3, B1, C2

/20./ 6 сартай хүүхэд өчигдөрөөс халуурсан, тайван биш болсон зовиуртай үзүүлэхэд чихнээс булаг гарч байв. Эх нь хүүхдийн чихнээс урд өмнө булаг гарч байсныг анзаараагүй тул хэд хоног гарч байгааг мэдэхгүй. Өөр шинжүүд илрээгүй. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?

- A. Чихний цочмог халдвар
- B. Халууралт Чихний архаг халдвар
- C. Халууралт Чихний цочмог халдвар
- D. Халууралт
- E. Маш хүнд халууралт өвчин

/21./ Нярайн тархины бор, цагаан бодисын зааг ямар байдаг вэ?

- A. Бүдэг
- B. Тод
- C. Жигд бус
- D. Зарим хэсгээр тод
- E. Зааг арилсан байна

/22./ Рахиттай гэж ангилаад эмчилгээний тунгаар Д аминдэм уулгасан хүүхдийг 30 хоноод давтан үзэхэд рахитын 2 шинж илэрч байв. Ямар арга хэмжээ авах вэ?

- A. Д аминдэм давтан уулгахгүй, эмчилгээг зогсооно.
- B. Д аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар залгаад өгнө.
- C. Сарын дараа Д аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар өгнө.
- D. 2 сарын дараа Д аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар өгнө.
- E. Эмчилгээний тунгаар Д аминдэм дахин нэг сар уулгана.

/23./ 6 сартай хүүхэд өчигдөрөөс халуурсан, тайван биш болсон зовиуртай үзүүлэхэд чихнээс булаг гарч байв. Эх нь хүүхдийн чихнээс урд өмнө булаг гарч байсныг анзаараагүй тул хэд хоног гарч байгааг мэдэхгүй. Өөр шинжүүд илрээгүй. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?

- A. Чихний цочмог халдвар
- B. Халууралт Чихний архаг халдвар
- C. Халууралт Чихний цочмог халдвар
- D. Халууралт
- E. Маш хүнд халууралт өвчин

/24./ 4 сартай хүнд тураалтай хүүхдэд ямар арга хэмжээ авах вэ?

- A. Тэжээх зорилгоор инсулинтэй глюкоз дуслар гэрээр хийнэ.
- B. Хооллолтын байдлыг үнэлэн хоолны зөвлөгөө өгнө.
- C. Фермент, аминдэм эмчилгээ хийж гэрт нь эмчилнэ.
- D. А аминдэм 50000 нэгжээр өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
- E. А аминдэм 200000 нэгжээр өгөөд, хооллох зөвлөгөө өгнө.

/25./ Амьсгалын зам хаанаас үүсдэг вэ?

- A. Урд гэдэс
- B. Мезодерм
- C. Эндодерм
- D. Эндодерм
- E. Зууван эс

/26./ Ямар тохиолдолд хүнд ужиг суулгалт гэж ангилах вэ?

- A. Суулгалт 20 хоногоос дээш үргэлжилсэн.
- B. Суулгалт 14 буюу түүнээс дээш хоног үргэлжилсэн ба шингэн алдалтын шинжтэй.
- C. Суулгалт 14 хоног ба түүнээс дээш үргэлжилсэн
- D. Суулгалт 14 хоног ба түүнээс дээш үргэлжилсэн бөгөөд баас цустай гарах.

/27./ Хүүхдийн сүүн шүд хэдэн сараас цухуйж эхэлдэг вэ?

- A. 2
- B. 4
- C. 6
- D. 8
- E. 7

/28./ Бантанг бэлтгэхдээ махыг нь сайтар хярж жижиглэн, дээр нь аарц, ээдэм, бяслаг, ногоо, өндөгний шарын аль нэгийг нэмнэ. Бантанг бэлтгэх энэ арга дээр юм нэмэх шаардлагатай юу?

- A. шаардлагагүй
- B. Цөцгий буюу ургамлын тос нэмнэ
- C. шар тос нэмнэ
- D. Хоол амтлагч нэмнэ

/29./ Бага насны хүүхэд пиелонефритээр өвдсөн үед бижийн хамшинж дараах байдлаар илрэнэ:

- A. Ховор
- B. Маш ховор
- C. Огт тохиолдохгүй
- D. Хааяа
- E. Элбэг

/30./ 4 настай хүүхэд суулгасан зовиуртай боловч орчиндоо идэвхитэй, цангаагүй, нүд хонхоогоогүй, арьсны хуниас хурдан арилж байв. Хүүхдийг үнэлж зохих зөвлөгөөг өг

A. Хүүхэд шингэн алдаагүй тул урьдчилан сэргийлэх зорилгоор суулгалт бүрийн дараа 100-200 мл шингэн уулга.

В. Хүүхэд шингэн алдаж болзошгүй тул 4 цагийн турш 1200-2200 мл ШСД-ыг аягаар бага багаар өг.

С. Хүүхэд шингэн алдаж байгаа тул 75 мл/кг жинд тооцоолон 3 цагийн турш ШСДУ уулгана.

Д. Хүүхэд шингэн их алдсан тул эмгэлэгт яаралтай хэвтүүлнэ.

Е. Хүүхэд шингэн их алдсан тул 100 мл/кг тооцоолон Рингер Лактатын уусмалыг судсаар дуслаар хийнэ.

/31./ 1сартай хүүхдийн амьсгалыг тоолоход хэд байвал олширсонд тооцох вэ?

A. 40

B. 42

C. 45

D. 50

E. 60

/32./ Монгол хүүхдийн хөдөлгөөн-сэтгэцийн хөгжлийг судалсан Г.Оросоо, Ш.Оросоо нарын ажиглалтаар бие дааж хийдэг үйлдэл аль нь вэ? (Дундажаар)

A. 3 сартайдаа толгойгоо дааж

B. 7 сартайдаа сууж

C. 9 сартайдаа мөлхөж

D. 12 сартайдаа явна

E. Бүгд зөв

/33./ 1 нас 2 сартай Дулмаа хөдөөнөөс хот шилжиж ирсэн. Өрхийн эмчдээ өнөөдөр бүртгүүлж байгаа. Хөдөө сумын эмч нь 6 сартай байхад нь хөх А аминдэм өгсөн гэсэн, дахин А аминдэм аваагүй тул өрхийн эмч өнөөдөр яах вэ? Үзлэгээр хүүхэд тураалгүй, рахитгүй, цус багадалтгүй, ба бусад өвчний шинжгүй.

A. Эрүүл тул А аминдэм өгөхгүй

B. 6 сартайдаа А аминдэм авсан тул давтан өгөхгүй

C. . 6 сартайдаа А аминдэм аваад сүүлийн 6 сар А аминдэм уугаагүй байгаа тул А аминдэмийн улаан капсулаас нэг ширхэгийг өгнө.

D. 6 сартайдаа А аминдэм аваад 8 сар өнгөрсөн байгаа тул А аминдэмийн хөх капсулаас нэг ширхэгийг өгнө.

E. 6 сартайдаа А аминдэм аваад 6 сар өнгөрсөн байгаа тул А аминдэмийн цагаан капсулаас нэг ширхэгийг өгнө.

/34./ Шуугиант амьсгал хяхтнаа амьсгалаас юугаар ялгаатай вэ?

A. Амьсгал авахад шуугиантай, зовиуртай

B. Амьсгал гаргахад шуугиантай, зовиуртай

C. Амьсгал авах, гаргах нь шуугиантай, зовиуртай

D. Амьсгал авахад хожигноо сонсогдоно

E. Уушги чагнахад гуурсан хоолойн амьсгал сонсогдоно

/35./ Таталдамхай өвчний далд хэлбэрийн шинжүүдийг хэрхэн шалгаж, илрүүлдгийг зөв сонгоно уу:

A. Хвостекийн шинж

B. Труссогийн шинж

C. Эрбагийн шинж

1. Бугалганы дотор талын ховил дахь мэдрэл судасны багцыг оноон чанга дарах, ороож боох зэрэгт тэр гарын сарвуу эх баригчийн гар шиг хумиж татах

2. 5mA-аас бага хүч бүхий цахилгаан гүйдлээр цочрооход булчингийн агчилт, таталт үүсэх

3. Хацрын хонхорт, нүүрний мэдрэлийн салааллыг оноон хурууны үзүүрээр чангахан дарахад нүүрний тэр талын булчингууд агчиж татах

A. A1, B3, C2

B. A1, B2, C3

C. C1, B2, A3

D. A2, B3, C1

E. A3, B1, C2

/36./ 3 сартай хүүхэд нэг хоног толгойгоо шөргөөж уйлна.Түүний чихэнд хүрэхэд маш ихэмзэглэн чанга уйлж байв. Чихний ард хөндүүр хаван байхгүй байна. Өөр шинжүүд илрээгүй.Хэрхэн ангилах вэ?

A. Рахит

- В. Хөхлөг ургацын үрэвсэл
- С. Чихний архаг халдвар.
- Д. Чихний цочмог халдвар
- Е. Менингит

/37./ Нярайн тархины цул хэд байдаг вэ?

- А. 113-125 г
- В. 226-239 г
- С. 339-345 г
- Д. 447-453 г
- Е. 555-570 г

/38./ Чихнээс булаг гарч буй хүүхдийн чихийг чихээсээр хэрхэн цэвэрлэх вэ?

А. Чихийг хуурайштал чихээсээр цэвэрлэнэ, хоногт 3-аас доошгүй удаа чихийг хуурайштал чихээсээр цэвэрлэнэ.

- В. Өглөө чихээс хийж орхиод орой чихээсийг шинээр солино
- С. Чихээсийг хоногт 2 удаа хийх ба нийт 5 хоног чихээсээр эмчилнэ
- Д. Чихийг чихээсээр 3 хоног эмчилнэ.
- Е. Гидрокортизоны тостой чихээс хийгээд 3 хоног орхино.

/39./ Хөврлийн хөгжлийн хэд дэх 7 хоногт амьсгалын зам үүсдэг вэ?

- А. 1-2 долоо хоног
- В. 2-3 долоо хоног
- С. 3-4 долоо хоног
- Д. 4-5 долоо хоног
- Е. 5-6 долоо хоног

/40./ Перинаталь үе гэдэгт дараах үе хамаарна

- А. Жирэмсний 22 долоо хоногтойгоос төрөлт эхлэх хүртэлх хугацаа
- В. Төрөлтийн үйл ажиллагаа эхлэхээс нярайн хүйг таслах хүртэлх хугацаа
- С. Төрсний дараах амьдралын эхний долоо хоног
- Д. Төрсний дараах амьдралын эхний 168 цагийн доторх хугацаа
- Е. Жирэмсний 22 долоо хоногтойгоос төрсний дараах эхний 7 хоног

/41./ Гэрээр эмчлэгдэж буй уушгины хатгалгаатай хүүхдийн давтан үзлэгийг хэзээ хийх вэ?

- А. 2 хоноод
- В. 5 хоноод
- С. 14 хоноод
- Д. 7 хоноод

/42./ Бага насны хүүхдийн пиелонефритын эмнэлзүйн гол ялгаа нь:

- А. Өвдөлтийн хамшинж
- В. Ерөнхий хордлогын хамшинж
- С. Хэсэг газрын үрэвслийн шинж
- Д. Цустай шээх шинж
- Е. Даралт ихсэх шинж

/43./ Улаанбурхэнтай 11 сартай хүүхдэд А аминдэмийн 100000 нэгжтэй, хөх капсулыг яаж өгөх вэ?

- А. 1 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1 капсулыг эхэд нь зааж өг.
- В. 1\2 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1\2 капсулыг эхэд нь өг.
- С. 1 капсулыг яаралтай өг.
- Д. 2 капсулыг яаралтай өг.
- Е. 3 капсулыг яаралтай өг.

/44./ Уушгины дэлбэнгийн үрэвсэл

- А. 1 хүртэлх насанд
  - В. 1-3 насанд
  - С. Сургууль цэцэрлэгийн насанд
1. Тохиолдохгүй
  2. Цөөн
  3. Голчилон тохиолдоно
- А. А1, В3, С2
  - В. А1, В2, С3

C. C1, B2, A3

D. A2, B1, C3

E. A3, B1, C2

/45./ 2 сартай хүүхдийн амьсгалыг тоолоход хэд байвал олширсонд тооцох вэ?

A. 40

B. 42

C. 45

D. 48

E. 50

/46./ Хүнд тураалтай хүүхдэд ямар арга хэмжээ авах вэ?

A. А аминдэм өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

B. Хооллолтын байдлыг үнэлэн хоолны зөвлөгөө өгнө.

C. Фермент, аминдэм эмчилгээ хийж гэрт нь эмчилнэ.

D. Дуслаар тэжээх зорилгоор инсулинтэй глюкоз гэрээр хийнэ.

E. Дексаметазон 4 мг-аар өглөө бүр уулгана.

/47./ Хэсэг газрын нянгийн халдвар байж болзошгүй гэж ангилсан нярайд ямар тусламж үзүүлэх вэ?

A. Үүсгэгчийн эсрэг эм уулгаад, цусны сахар багасхаас сэргийлээд, эмнэлэг яаралтай хэвтүүлнэ.

B. Антибиотикийн эхний тунг тариад, цусны сахар багасхаас сэргийлээд, дулаан авч явахыг зөвлөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

C. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эм уулгаад гэртээ хэрхэн асрах талаар эхэд зааж өгнө.

D. Эмнэлэгт хэвтүүлнэ.

E. Үүсгэгчийн эсрэг эм уулгаад, хэсэг газрын халдварыг генцианвиолетээр гэрт нь эмчлэнэ. 2 хоноод давтан үзнэ.

/48./ Хяхтнаа амьсгал юугаар ялгагдах вэ?

A. Амьсгал авахад шуугиантай, зовиуртай

B. Амьсгал гаргахад шуугиантай, зовиуртай

C. Амьсгал авах, гаргах нь шуугиантай, зовиуртай

D. Амьсгал гаргахад хожигноо сонсогдоно

E. Уушги чагнахад гуурсан хоолойн амьсгал сонсогдоно

/49./ Мукополисахаридоз өвчний эхний 3 хэвшинжүүдийн үед илрэх эмнэлзүйн шинжүүдийг зөв сонгоно уу:

A. 1-р хэвшинж

B. 2-р хэвшинж

C. 3-р хэвшинж

1. Сэтгэцийн хөгжил хоцрох, толгойн ясны хөгжил гажих, хэл томорч, шүд жижигрэх, чихний дэлбээ өөрчлөгдөх, эвэрлэг булингартах, өсөлт хоцрох, зүрхний гажиг г.м өөрчлөлтүүд илрэх

2. Сэтгэцийн хөгжлийн даамжрах хоцролт, үений хөдөлгөөн хязгаарлагдахгүй, элэгний томрол дэлүүний томролгүй, дүлийрэлт

3. Өвчний явц харьцангуй хөнгөн, зөвхөн эрэгтэй хүүхдэд тохиолдоно, элэг дэлүү томрох, зүрхний эмгэгшил, харааны мэдрэлийн хөхлөгийн судас агчин, хаванших шинжүүд давамгайлах

A. A1, B3, C2

B. A1, B2, C3

C. C1, B2, A3

D. A2, B3, C1

E. A3, B1, C2

/50./ Рахиттай гэж ангилаад эмчилгээний тунгаар Д аминдэм уулгасан хүүхдийг 30 хоноод давтан үзэхэд рахитын шинжгүй болсон байв. Ямар арга хэмжээ авах вэ?

A. Д аминдэм давтан уулгахгүй, эмчилгээг зогсооно.

B. Д аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар залгаад өгнө.

C. Сарын дараа Д аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар өгнө.



- D. 2 сарын дараа Д аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар өгнө  
E. Өвөл Д аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар 3 сар өгнө.
- /51./ 3 сартай хүүхэд нэг хоног толгойгоо шөргөөж уйлна.Түүний чихэнд хүрэхэд маш ихэмээглэн чанга уйлж байв. Чихний ард хөндүүр хаван байхгүй байна. Өөр шинжүүд илрээгүй.Хэрхэн ангилах вэ?
- A. Рахит
  - B. Хөхлөг ургацын үрэвсэл
  - C. Чихний архаг халдвар.
  - D. Чихний цочмог халдвар
  - E. Менингит
- /52./ Чихний цочмог халдвартай хүүхдийн чихний өвдөлтийг намдаахаар бага эмч юу зөвлөх вэ?
- A. Чихэнд фурациллинтэй спирт дусаах
  - B. Парацетамолыг 6 цагаар өвдөлт намдтал уулгах.
  - C. Тарвагны тос халаагаад чихэнд дусаах
  - D. Чихний ард новокаинтэй блокад хийх
  - E. Анальгин, димедролтой тарих.
- /53./ Гаррисоны ховилын шинж гэж юу вэ?
- A. Хавирга зөөлөрснөөс цээж өрц бэхлэгдсэн хэсгээрээ дотогш татагдах
  - B. Хавирганы ясан ба мөгөөрсөн хэсгийн зааг дээр яс төст эд ургах
  - C. Үе мөч хавдаж, улайн халуу оргих
  - D. Үе мөчинд контрактур, анкилоз үүсэх
  - E. Гавлын хавтгай ясны төвд яс төст эд ургах
- /54./ Шаржигнасан нойтон хэржигнүүр ямар үед сонсогдох вэ?
- A. Уушгины нэвчдэст үрэвсэл
  - B. Уушгины үрэвсэл
  - C. Уушгины хаван
  - D. Гуурсанцрын үрэвсэл
  - E. Бүгд нь сонсогдоно
- /55./ 6-12 сартай хөхөө хөхдөг хүүхдэд нэмэгдэл хоолнуудад дасгасны дараа өдөрт хэдэн удаа нэмэлт хоол өгөх вэ?
- A. 1-2 удаа
  - B. 3 удаа
  - C. 5 удаа
  - D. 4 удаа
  - E. 6 удаа
- /56./ Шүүдэст эмзэгшилтэй хүүхдийн цусны дэлгэрэнгүй шинжилгээнд илрэх эмнэлзүйн ач холбогдол бүхий өөрчлөлтийг зөв сонгоно уу.
- A. Лейкоцитоз
  - B. Лимфоцитоз
  - C. Нейтропени
  - D. Эозинофили
  - E. СОЭ өндөрсөх
- /57./ Хүүхэд хэдэн наснаас инээмсэглэж сэтгэл хөдлөлөө илэрхийлдэг вэ?
- A. 1 сар
  - B. 1.5 сар
  - C. 2.5 сар
  - D. 3 сар
  - E. 4 сар
- /58./ Хүүхэд 4 сартай, хүнд тураалтай гэж ангилагдсан. Өрхийн эмчид улаан, хөх, цагаан А аминдэм байна. Өрхийн эмч ямар арга хэмжээ авах вэ?
- A. Улаан А аминдэмээс (200000 нэгж) нэг капсулыг өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
  - B. Цагаан А аминдэмээс (50000 нэгж) нэг капсулыг өгөөд, цусны сахар багасахаас сэргийлээд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
  - C. Хөх А аминдэмээс (100000 нэгж) нэг капсулыг өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ

D. Цагаан А аминдэмээс нэг капсулыг өгөөд, хооллох талаар эхэд зөвлөгөө өгөөд 5 хоноод давтан үзнэ.

E. Цагаан А аминдэмээс нэг капсулыг өгөөд, хооллох талаар эхэд зөвлөгөө өгөөд 30 хоноод давтан үзнэ

/59./ Улаанбурхантай 2 настай хүүхдэд А аминдэмийн 200 000 МЕ-тэй капсулыг яаж өгөх вэ?

A. 1 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1 капсулыг эхэд нь яаж уулгахыг заагаад өг.

B. 1½ капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1½ капсулыг эхэд нь өг.

C. 1 капсулыг нэг удаа өг.

D. 2 капсулыг нэг дар уулгах.

E. 3 дуслыг өнөөдөр өг.

/60./ Ургийн хөгжлийн хэд дэх 7 хоногт мэдрэлийн тогтолцоо үүсч эхэлдэг вэ?

A. Эхний 7 хоногт

B. 2 дахь 7 хоногт

C. 3 дахь 7 хоногт

D. 4 дэх 7 хоногт

E. 5 дахь 7 хоногт

/61./ Уушгины хатгалгаатай 9 сартай хүүхдийг 2 хоноод давтан үзэхэд биеийн байдал нь дордсон, ханиалгасан хэвээр, цээж нь хонхолзож байв. Ямар арга хэмжээ авах вэ?

A. Эмчилгээг зогсооно.

B. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эмийг өгнө.

C. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

D. Үүсгэгчийн эсрэг нэгдүгээр сонголтын эмийг үргэлжлүүлэн өгнө.

E. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эмийг өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

/62./ Хэрэв хүүхэд нүд буюу амны хүндрэлтэй улаанбурхантай бол давтан үзлэгт хэд хоногийн дараа эргэж ир гэж эхэд зөвлөх вэ?

A. 5 хоног

B. 2 хоног

C. 7 хоног

D. 14 хоног

E. 30 хоног

/63./ 3 настай уушгины хатгаатай хүүхдэдамоксициллины 250 мг шахмалыг яаж өгөх вэ?

A. 1½ -талаар

B. 1 бүтнээр

C. 2 1½ ширхэгээр

D. 1/4

/64./ Бага насны хүүхдийн хамрын дайвар хөндий хэдэн наснаас үүсч эхэлдэг вэ?

A. 6 сараас

B. 1 наснаас

C. 2 наснаас

D. 3 наснаас

E. 4 наснаас

/65./ Улаанбурхэнтай 11 сартай хүүхдэд А аминдэмийн 100000 нэгжтэй, хөх капсулыг яаж өгөх вэ?

A. 1 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1 капсулыг эхэд нь зааж өг.

B. 1½ капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1½ капсулыг эхэд нь өг.

C. 1 капсулыг яаралтай өг.

D. 2 капсулыг яаралтай өг.

E. 3 капсулыг яаралтай өг.

/66./ Гуурсан хоолойн цочмог үрэвслийн хэлбэр, эмнэлзүйн явц нь хүүхдийн нас, суурь өвчин, харшилтай эсэхээс хамаарна:

A. 6 сар хүртэлх насны хүүхэд

B. 6-12 сартай хүүхэд

C. Бага ба сургуулийн насны хүүхэд

1. Гуурсанцар хоолойн үрэвсэл зонхилж, эмнэлзүйн хүнд хэлбэр буюу хүнд цочмог хатгалгаатай төстэй.

2. Гуурсан хоолойн энгийн үрэвсэл тохиолдох ба өвчний эхний үед хуурай хүчтэй ханиалгах ба ихэвчилэн 3-4 хоногийн дараагаас нойтон ханиалгаж цэр ховхорч эхэлнэ.

3. Гуурсан хоолойн бөглөрөлтөт үрэвсэл давамгайлдаг тул энгийн хэлбэрээс хүнд явцтай.

A. A1, B3, C2

B. A1, B2, C3

C. C1, B2, A3

D. A2, B1, C3

E. A3, B1, C2

/67./ Таталдамхай өвчний анхдагч урьдчилан сэргийлэлтийг зөв сонгоно уу:

A. Витамин А уулгах

B. Кальцийн бэлдмэл өгөх

C. Рахитаас сэргийлэх

D. Таталт тавиулах бэлдмэл хэрэглэх

E. Сийвэнгийн кальцийг тогтмол хянах

/68./ Дөнгөж төрсөн нярайд тогтворжоогүй байдаг нь аль нь вэ?

A. Харц

B. Сонсгол

C. Тэнцвэр

D. Дуу авиа ялгах чадваргүй

E. Бүгд

/69./ Тунгалгын эмзэгшилтэй хүүхдэд ямар шинжүүд илрэх вэ?

A. Хөлрөмтгий, шилээ шөргөөдөг, дагзны үс халцрах.

B. Нурамтгай, толгойд зузаан хагтай, арьсанд тууралт гарах нь хялбар

C. Цочромтгой, өвчлөмтхий, тунгалгын зангилаанууд томорсон, сэрээ булчирхай томорсон.

D. Гульгимтхай, цочромтхой, гиперрефлексүүдтэй. .

E. Шээх бүр уйлж сэрдэг, шээс нь улаан шар өнгөтэй.

/70./ Чихний цочмог халдвартай хүүхдийг 5 хоноод давтан үзэхэд өвдөлт нь ихэссэн, хүүхэд өндөр халуурсан байвал ямар арга хэмжээ авах вэ?

A. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эм өгөөд 2 хоноод давтан үзнэ.

B. Эмнэлэгт яаралтай хэвтүүлж эмчилнэ.

C. Үүсгэгчийн эсрэг нэгдүгээр сонголтын эм дээр парацетамолыг нэмж өгнө

D. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эм, парацетамол өгөөд, чихийг чихээсээр хуурайшуулахыг зааж өгөөд 2 хоноод давтан үзнэ.

/71./ 4 сартай хүүхэд ханиалгасан ба түүний амьсгал 1 минутанд 42 байна. Өөр эмгэг шинжгүй. Та яаж ангилах вэ ?

A. Уушгины хүнд хатгалгаа буюу маш хүнд өвчин

B. Уушгины хатгалгаа.

C. Уушигны хатгалгаагүй ханиад шуухнаа.

D. Томуу

E. Маш хүнд өвчин.

/72./ Гликогеноз өвчний хэвшинжүүдийн үед илрэх эмнэлзүйн шинжүүдийг зөв сонгоно уу:

A. Гиркегийн өвчин

B. Помпегийн өвчин

C. Горийн өвчин

1. Булчингийн сулрал, зүрх томрох, зүрхний дамжуулах чанар алдагдах шинжүүд илрэх ч харьцангуй хөнгөн явцтай

2. Элэг аарцаг хүртэл томрох, өсөлт удаашрах, хүүхэлдэйн царай, хоолны дуршил ихсэх, бөөлжих, булчин сулрах

3. Булчингийн хүчдэл сулрах, амьсгаадах, хөхрөх, зүрх томрох

A. A1, B3, C2

B. A1, B2, C3

C. C1, B2, A3

D. A2, B3, C1

Е. А3, В1, С2

/73./ Улаанбурхантай 2 настай хүүхдэд А аминдэмийн 200 000 МЕ-тэй капсулыг яаж өгөх вэ?

- А. 1 капсулыг яаралтай өг, маргааш уулгах 1 капсулыг эхэд нь яаж уулгахыг заагаад өг.
- В.  $1\frac{1}{2}$  капсулыг яаралтай өг, маргааш уулгах  $1\frac{1}{2}$  капсулыг эхэд нь өг.
- С. 1 капсулыг нэг удаа өг.
- Д. 2 капсулыг нэг дар уулгах
- Е. 3 дуслыг өнөөдөр өг.

/74./ Чихний архаг халдвартай гэж ангилсан хүүхдэд эмч ямар арга хэмжээ авах вэ?

- А. Үүсгэгчийн эсрэг эм, өвдөлт намдаах эм өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
- В. Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног өгөөд, өвдөлт намдаах ба чихээсээр чихийг цэвэрлэх эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ.
- С. Чихээсээр чихийг хуурайшуулахыг зааж өгөөд 5 хоноод давтан үзүүлэхийг ба хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг зөвлөнө.
- Д. Өвдөлт намдаах эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ.
- Е. Котримоксазол хоногт 2 удаа 5 хоног уулгана.

/75./ “Ногоон мөчрийн хугарал” хэлбэрийн ясны хугарал хэнд илүү тохиолддог вэ?

- А. Өндөр настан
- В. Хүүхэд
- С. Аль нь ч биш
- Д. 20-25 насанд
- Е. 45-55 насанд

/76./ Суулгаж байгаа хүүхдэд саагийн вакцин уулгах уу?

- А. Уулгах боловч тунг хийсэнд тооцохгүй.
- В. Дархлаа тогтохгүй учир уулгахгүй.
- С. Уулгаад товлолын дагуу уусанд тооцно.
- Д. Уулгахгүй, учир нь суулгалтаар гарчихна.
- Е. Уулгахгүй, учир нь дархлаад нөлөөлсөн эсэхийг мэдэх боломжгүй.

/77./ Хэрлэгийн үеийн хоёр хавтаст хавхлагын дутагдал рентгенд ямар дүрсээр илэрхийлэгддэг вэ?

- А. Майхан
- В. Митраль
- С. Гутлын
- Д. Хөндлөн томрол
- Е. Модон шаахай

/78./ 38,5 хэмээс дээш хэлуурч буй 4 настай хүүхдэд парацетамолын 500 мг-ын шахмалаас яаж өгөх вэ?

- А.  $\frac{1}{4}$  шахмал
- В.  $1\frac{1}{2}$  шахмал
- С. 1 бүтнээр
- Д. 1,5 шахмал
- Е. 2 бүтнээр

/79./ 4 сартай Улаанбаатарын хүүхэд товлолын дагуу вакцинуудаа хийлгэсэн. Өнөөтөө ямар вакцин хийлгэх вэ?

- А. БЦЖ, ВГ, саа
- В. Тавт вакцины III тун, саагийн IV тун
- С. СХХТ III тун, саагийн IV тун
- Д. СХХТ III тун, саагийн III тун
- Е. УБ I, ВГ III

/80./ Шүүдэст эмзэгшилтэй нярайд ямар шинжүүд илрэх вэ?

- А. Хөлрөмтгий, шилээ шөргөөх, дагзны үс халцрах.
- В. Нурамтгай, толгойд зузаан хагтай, жин хурдан нэмэгдэх.
- С. Идээт цэврүүнүүд арьсан дээр гарч халуурах, хөхөндөө дургуйцах
- Д. Гульгимтхай, цочромтхой, нойронд муу.
- Е. Шээх бүр уйлж сэрдэг, шээс нь улаан шар өнгөтэй.

/81./ Шингэн алдалтгүй, цусан суулгалттай хүүхдийг 2 хоноод давтан үзэхэд шингэн алдалтгүй, цусан суулгалт намдаагүй, хүүхэд янзандаа байвал ямар арга хэмжээ авах вэ?

A. Котримоксазолыг үргэлжлүүлэн өгөөд 2 хоноод давтан үзнэ.

B. Эмнэлэгт хэвтүүлж эмчилнэ.

C. Хоёрдугаар сонголтын үүсгэгчийн эсрэг эм өгөөд 2 хоноод давтан үзнэ

D. Хоёрдугаар сонголтын үүсгэгчийн эсрэг эм өгөөд 5 хоноод давтан үзнэ.

E. Шингэн алдалтгүй тул А төлөвлөгөөгөөр суулгалтыг гэрээр эмчилнэ.

/82./ Хүний оюуны чадавхийн 50% нь хэдэн насанд илэрдэг вэ?

A. 2 нас

B. 3 нас

C. 4 нас

D. 5 нас

E. 6 нас

/83./ Уушгины хатгалгаатай 2 настай хүүхдийг 2 хоноод давтан үзэхэд биеийн байдал нь сайжирсан, ханиалга намдсан, амьсгал минутанд 32 байв. Ямар арга хэмжээ авах вэ?

A. Эмчилгээг зогсооно.

B. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эмийг өгнө.

C. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

D. Үүсгэгчийн эсрэг нэгдүгээр сонголтын эмийг үргэлжлүүлэн өгнө.

E. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эмийг өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ

/84./ 38,5 хэмээс дээш халуурч буй 4 настай хүүхдэд парацетамолын 500 мг-ын шахмалаас яаж өгөх вэ?

A. 1\4

B. 1\2

C. 1 бүтнээр

D. 1,5

E. 2 бүтнээр

/85./ Улаанбурхантай 13 сартай хүүхдэд 50 000 ME-тэй А аминдэмийг хэдэн капсулаар өгөх ёстой вэ?

A. 1 капсул

B. 2 капсул

C. 3 капсул

D. 4 капсул

E. 5 капсул

/86./ 6 сартай уушгины хатгалгаатай хүүхдэд амоксациллин 250 мг шахмалыг яаж өгөх вэ?

A. 1\2 -талаар

B. 1\2 бүтнээр

C. 2 ширхэгээр

D. 1\4

/87./ Амьсгалын замыг хэд хуваадаг вэ?

A. 1

B. 2

C. 3

D. 4

E. 5

/88./ 2 сартайгийнхаа вакцины дараа 3 хоногийн дотор татсан хүүхдэд 3 сартайд нь ямар вакцин хийж болох вэ?

A. СХХТ2

B. Саа 3

C. ВГ 3

D. УБ 1

E. БЦЖ 1.

/89./ Нусгайралтыг үүсгэж буй шалтгаанаар нь өөр хооронд нь ялган оношлоно:

A. Вирус

B. Харшил

C. Сахуу

1. Хамар шархиран загатнаж, олон дахилттай, архаг явцтай
2. Хамрын нэг талаас цусархаг, идээрхэг нус гоожно
3. Богино хугацаанд олон хүнд халдвар тархана

- A. B3, A1, C2
- B. A1, B2, C3
- C. C1, B2, A3
- D. A2, B1, C3
- E. A3, B1, C2

/90./ Таталдамхай өвчний үед огт хэрэглэж болохгүй эмийн бэлдмэлийн зөв сонгоно уу:

- A. Витамин Д
- B. Кальцийн бэлдмэл
- C. Таталт тавиулах бэлдмэл
- D. Бикарбонат натри
- E. Антибиотик

/91./ Амны аль нэг буланд хуруугаа хүргэхэд тэр тал уруу толгойгоо эргүүлж, амаа ангайлган хэлээ булталзуулна

- A. Уруул цорвойх рефлекс
- B. Хайх рефлекс
- C. Хөхөх рефлекс
- D. Галантын рефлекс
- E. Бауэрийн рефлекс

/92./ 4 настай хүүхэд ханиалгасан ба түүний амьсгал 1 минутанд 42 байна. Өөр эмгэг шинжгүй. Та яаж ангилах вэ ?

- A. Уушгины хүнд хатгалгаа буюу маш хүнд өвчин
- B. Уушгины хатгалгаа.
- C. Уушигны хатгалгаагүй ханиад шуухнаа.
- D. Томуу
- E. Маш хүнд өвчин.

/93./ Бөөрний түүдгэнцрийн архаг үрэвслийн эмнэлзүйн хэлбэрүүдийг онцлох шинжээр нь ялган оношлоно уу:

- A. Цусаар шээх
- B. Уургаар шээн, хавагнах
- C. Холимог

1. Өвчний эхлэл үед микрогематури, бага зэргийн протеинури
2. Гипопротеинеми, гиперлипидеми
3. Гематури, хаван, даралт ихсэлт, их хэмжээний протеинури

- A. A1, B3, C2
- B. A1, B2, C3
- C. C1, B2, A3
- D. A2, B3, C1
- E. A3, B1, C2

/94./ Хөхлөг ургацын үрэвсэлтэй хүүхдэд эмч ямар арга хэмжээ авах вэ?

A. Үүсгэгчийн эсрэг эм, өвдөлт намдаах эмийн гараа тун өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.

B. . Үүсгэгчийн эсрэг эм 5 хоног өгөөд, өвдөлт намдаах ба чихээсээр чихийг цэвэрлэх эмчилгээ заагаад гэрээр эмчилнэ

C. Антибиотик булчинд тариад гэрт нь 5 хоног эмчилнэ.

D. 2 антибиотик булчинд тариад, өвдөлт намдаах эм, тайвшруулах эм хэрэглээд 5 хоног гэрт нь эмчилнэ.

/95./ Нүдний халдварыг тетрациклины тосоор эмчлэхдээ хоёр нүдийг хэдэн удаа цэвэрлэх ёстой вэ?

- A. 1 удаа
- B. 2 удаа
- C. 3 удаа
- D. 4 удаа
- E. 5 удаа

/96./ Гэрээр эмчлэгдэж буй уушгины хатгалгаатай хүүхдийн давтан үзлэгийг хэзээ хийх вэ?

- A. 2 хоноод
- B. 5 хоноод
- C. 14 хоноод
- D. 7 хоноод
- E. 30 хоноод

/97./ Илүү тээлттэй нярайн дасан зохицох эрт үеийг уялдуулан сонгоно уу:

- A. 1-р зэрэг
- B. 2-р зэрэг
- C. 3-р зэрэг

1. Булчингийн хүчдэл сул, рефлексүүд амархан туйлддаг.
2. Уушги тархины эмгэг өөрчлөлтүүд, дотор эрхтэний хямрал
3. Цочромтгой, амьсгал тасалдах, гульгих, биеийн дулаан багасах, хахаж бүтэх, АД буурах

- A. A1, B3, C2
- B. A2, B1, C3
- C. C1, B2, A3
- D. A2, B3, C1
- E. A3, B1, C2

/98./ Чихнээс булаг гарч буй хүүхдийн чихийг чихээсээр хэрхэн цэвэрлэх вэ?

A. Чихийг хуурайштал чихээсээр цэвэрлэнэ, хоногт 3-аас доошгүй удаа чихийг хуурайштал чихээсээр цэвэрлэнэ.

- B. Өглөө чихээс хийж орхиод орой чихээсийг шинээр солино.
- C. Чихээсийг хоногт 2 удаа хийх ба нийт 5 хоног чихээсээр эмчилнэ.
- D. Чихийг чихээсээр 3 хоног эмчилнэ.
- E. Гидрокортизоны тостой чихээс хийгээд 3 хоног орхино.

/99./ Халууралттай, өөр өвчний шинжгүй 1 настай хүүхдийг 2 хоноод давтан үзэхэд халуун нь үргэлжилж, ханиалгаж, амьсгал нь минутанд 42 болсон байв. Ямар арга хэмжээ авах вэ?

- A. Ханиад шуухнаа гэж ангилаад ханиад намдаах эм бичиж өгнө.
- B. Хүндэрсэн ханиад шуухнаа гэж ангилаад үүсгэгчийн эсрэг эм өгнө.
- C. Уушгины хатгалгаа. Халууралт.-гэж ангилаад үүсгэгчийн эсрэг эм, ханиад зөөлрүүлэх эм, халуун бууруулах эм өгнө.
- D. Уушгины хүнд хатгалгаа гэж ангилаад эмнэлэгт хэвтүүлнэ.
- E. Маш хүнд халууралт өвчин гэж ангилаад эмнэлэгт хэвтүүлнэ.

/100./ 10 хоногтой нярайн арьс өтгөн шар ногоон өнгөтэй байвал өрхийн эмч ямар арга хэмжээ авах вэ?

- A. 10 хоногтой нярайд физиологийн шарлалт байх ёстой тул ямар ч эмчилгээ хэрэггүй
- B. Нярайн физиологийн шарлалт 10 хоногт арилах ёстой тул шарлалт сунжирч байна гэж үзээд карболен хоногт 3 удаа уухаар, люминал 0,005 хоногт 3 удаа уухаар бичиж өгнө.
- C. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
- D. Гэрээр эмчлээд 5 хоногийн дараа давтан үзээд шарлалт арилаагүй бол эмнэлэгт хэвтүүлнэ
- E. 5 хоног ажиглаад шарлалт арилаагүй бол эмнэлэгт хэвтүүлнэ.

/101./ Тунгалаг эс хэдэн өдөр амьдардаг вэ?

- A. 50-100
- B. 25-50
- C. 100-300
- D. 10-14
- E. 7-14

/102./ Тураалтай, цус багадалттай, хооллолтын бэрхшээлтэй 6 сартай хүүхдийг давтан үзэх хамгийн ойрын хугацаа:

- A. 2 хоноод
- B. 5 хоноод
- C. 7 хоноод
- D. 14 хоноод
- E. 30 хоноод

/103./ 38,5 хэмээс дээш хэлуурч буй 8 сартай хүүхдэд парацетамолын 100 мг- ын шахмалаас яаж өгөх вэ?

- A. 1\4
- B. 1\2
- C. 1 бүтнээр
- D. 1,5
- E. 2 бүтнээр

/104./ 3 настай хүүхдийн чихнээс булаг гойжоод 7 хонож байгаа . Гэтэл өчигдрөөс эхлээд хүүхэд халуурч, чих өвдөж байна гэж уйлагнасан. Үзлэгээр чихнээс булаг гарч байсан, чихний ард хөндүүр хавдсан байв. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?

- A. Чихний цочмог халдвар
- B. . Чихний архаг халдвар
- C. Хөхлөг ургацын үрэвсэл
- D. Шингэн хулхи
- E. Хэсэг газрын халдвар

/105./ 12 сараас 5 хүртлэх насны хүүхдийн амьсгал олшрох борго хэд вэ?

- A. 1 минутанд 50 буюу түүнээс дээш.
- B. 1 минутанд 40 буюу түүнээс дээш.
- C. 1 минутанд 60 буюу түүнээс дээш.
- D. 1 минутанд 30 буюу түүнээс дээш.

/106./ Лапласын хууль ёсоор эхлээд ямар цулцан тэлэх вэ?

- A. Жижиг цулцан
- B. Дунд цулцан
- C. Том цулцан
- D. Хажуугийн цулцан
- E. Өмнөд цулцан

/107./ Улаанбурханы вакцины 1-2-р тунг хэдэн сарын зайтай хийх ёстой вэ?

